



**НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ТУЯАГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт



Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
			1	2	3	4	5
Зорилт 1. “Орчны эрүүл мэндийн бодлого” зорилтын хүрээнд							
1.1	ЭМССТ 1.11 “Орчны эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Арга хэмжээний хэрэгжилт 60%-д хүрсэн.	Арга хэмжээний хэрэгжилт 70% хувьд хүрсэн байна.	“Орчны эрүүл мэнд” хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/349 дүгээр тушаалаар батлан, 2021-2024 онд нийт 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан. 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 80%-тай байна.	2024.01.02 2024.12.31	100% 
1.2	ЗГҮАХ 2.1.12.2 Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, улсын хэмжээнд хэрэгжүүлэх	-Шинээр аудит эрсдэлийн үнэлгээ хийсэн байгууллагын тоо -Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулсан байгууллагын тоо	16 аймгийн ус хангагч байгууллага д УАБТ-ний хэрэгжилтэд хөндлөнгийн аудит хийсэн.	2 аймагт аудит, 4 жижиг суурин газарт УАБТ-г боловсруулах, хэрэгжилт 50 хувиас доош байгаа 2 хангагч байгууллагад талбарын сургалт, усны чанар, аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийнэ.	2024 онд Баянхонгор аймгийн Бууцагаан сум, Говь-Алтай аймгийн Баян-Уул сум, Ховд аймгийн Зэрэг суманд Усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит хийх, сонгогдсон сумын ус хангамжийн тогтолцоонд эрсдэлийн үнэлгээ хийх, төлөвлөгөөний төслийг боловсруулах, ус хангагч байгууллагын ажилчдад сургалт зохион байгуулах ажлын удирдамж, төсвийг батлуулан Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. 2024 оны 08 дугаар сарын 21-30-ны өдрүүдэд Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Баян-Уул сум, Баянхонгор аймгийн Бууцагаан сум, Ховд	2024.04.01 2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
					аймгийн Зэрэг суманд ДЭМБ-ын дэмжлэгтэйг үндэсний зөвлөхөөр бэлтгэгдсэн аудиторууд ажиллаж Усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит сонгогдсон сумын ус хангамжийн тогтолцоонд эрсдэлийн үнэлгээ, ус хангагч байгууллагын ажилчдад сургалт зохион байгуулж ажилласан. Үнэлгээний үйл ажиллагааны тайлан болон мөнгөн урьдчилгааны тайланг эцэслэн боловсруулж Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулан ДЭМБ-д хүргүүлсэн.		
1.3	ЗГҮАХ 5.1.4.2 Аялал жуулчлалын бааз болон худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангуулах.	Шинээр гаргасан МСС-ны материалын төрөл, тоо	Стандартын бус нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрсний бохирдлоос сэргийлэх чиглэлээр 1 брошур, 13 төрлийн инфографик , 1 баримтат видео боловсруулсан.	Ариун цэврийн байгууламжийг сайжруулах, хөрсний бохирдлоос сэргийлэх талаар зөвлөмж, гарын авлага, инфографик, видео шторк боловсруулна.	Хөрсний бохирдлоос сэргийлэх ажлын хүрээнд 2024 оны 4 дүгээр сарын 15-наас 05 дугаар 30-ны хугацаанд “Хоггүй-орчин, бидний хариуцлага” уриатай аяныг өрнүүлэн, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд цахим сургалт зохион байгуулсан. Аяны хүрээнд улсын хэмжээнд 50 орчим аж ахуйн нэгж байгууллага Хоггүй-орчин, бидний хариуцлага” уриатай аяныг өрнүүлэн ажилласан. Стандартын бус нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрсний бохирдлоос сэргийлэх “Эрүүлийг хүсвэл хэмжиж төлөвлө”, “Цусан суулга өвчний 90 хувь нь хөрсний бохирдлоос үүсдэг учраас ЭКО жорлонг сонгох”, “Ялгааг ол”, “Хог хаягдлыг бууруулах 5 зарчим” зэрэг 4 төрлийн инфографик боловсруулсан. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 160 тоот албан бичгээр Улаанбаатар	2024.07.01 2024.12.30	100% 

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
					хотын гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон болон улсын хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын ариун цэврийн байгууламжийн талаарх судалгаа, тоон мэдээллийг ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлж ажиллан нийт орон нутийн хэмжээнд 700, нийслэлийн 481 аж ахуйн нэгж байгууллагын судалгаа мэдээллийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэсэн. Шар усны үер, нүхэн жорлонгийн бохирдолтой холбоотой цуврал 18 инфографик, цуврал 3 подкаст зөвлөмжийг боловсруулж, ЭМЯ болон НЭМҮТ-ийн цахим хуудсанд нийтэлсэн. Дэлхийн 00-ийн өдөртэй холбогдуулан нүхэн жорлонтой холбоотой 3 төрлийн инфографик, 1 баннер боловсруулж, ЭМЯ болон НЭМҮТ-ийн цахим хуудсанд нийтэлж хүн амд түгээсэн. "Дэлхийн 00-ын өдөр"-ийг угтуулан 2024 оны 11 дүгээр сарын 18-ний өдөр "Жорлон бол амар тайван орчин" сэдэвт цахим сургалтыг аймаг, сум, дүүргийн 100 гаруй мэргэжилтнүүдэд нүхэн жорлонг хэрхэн сайжруулах талаарх мэдээллийг хүргүүлсэн.		
1.4	Агаарын тухай хуулийн 21.4 Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс	Эрүүл мэндийн сайдын тушаал	Тушаалын төсөл боловсруулсан.	Холбогдох байгууллагуудад хүргүүлж, тушаалын хэрэгжилтийг хангана.	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийн хамгаалалтын бүсийн хэмжээг тогтоох жагсаалтын төслийг эцэслэн боловсруулж "Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, Ерөнхий шаардлага MNS 5105:2001 стандарт"-д дурдагдаагүй орчиндоо эрсдэл бүхий хүчин зүйл үүсгэн үйл ажиллагаа явуулдаг 14	2024.01.02 2024.12.30	100% 90%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	тогтоож, жагсаалт батлуулах.				чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагад эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээг тогтоох Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн тушаалаар батлуулсан.		
1.5	Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан Хүрээлэн буй орчин-Эрүүл мэнд 6 ажлын хэсгийн тушаалын хэрэгжилтийг хангах	Уулзалт, хэлэлцүүлгийн тоо Батлагдсан төлөвлөгөө	Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/482, А/657 дугаар тушаал батлагдсан.	Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг 50%-иас доошгүй хангаж ажилласан байна.	Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Хүрээлэн буй орчин-Эрүүл мэнд" сэдэвт 6 ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга нарын уулзалтыг 4 удаа зохион байгуулсан. Хамтарсан тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд агаар, ус ариун цэврийн байгууламж, химийн аюулгүй байдал, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ажлын хэсгийн бүрэлдэхүүний салбар хоорондын нэгдсэн зөвлөлдөх уулзалтыг 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж 120 гаруй гишүүд оролцсон. Ажлын хэсгийн явцын уулзалтаар 2024-2025 оны төлөвлөгөөг хэлэлцэн боловсруулж, Эрүүл мэндийн Дэд сайдаар батлуулан хувийг Байгаль орчин аялал, жуулчлалын яаманд 2024 оны 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 16/2495 албан тоотоор хүргүүлж ажилласан. Ажлын хэсгүүдийн ээлжит хурлыг 10-11 дүгээр сард тус бүр хоёр удаа зохион байгуулж, 2024 онд төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн явц, 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлэлцсэн.	2024.01.02 2024.12.31	100% <i>gdl</i>
1.6	Уур амьсгалын өөрчлөлт хүний эрүүл мэндэд үзүүлэх	Судалгааны арга, аргачлал Судалгааны тайлан	Судалгааны арга аргачлал батлагдсан.	Уур амьсгалын өөрчлөлт хүний эрүүл мэндэд үзүүлэх	Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр Даян дэлхийн ногоон хөгжлийн институт GGGI, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын	2024.01.02 2024.11.29	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
	нөлөөллийн чиглэлээр судалгааны ажил хийх, үр дүнг түгээх			нөлөөллийн чиглэлээр судалгааг хийж үр дүнг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	ажиллагааны төвтэй хамтран “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийг хэрэгжүүлэх техникийн болон тогтолцооны чадавхыг бэхжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд тусгах нь” төслийн хүрээнд “Уур амьсгалын өөрчлөлт, хоол тэжээл хүнсний аюулгүй байдал”-ын талаарх судалгааны дүнг танилцуулах зөвлөлдөх уулзалтыг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулан ажилласан. Судалгааны үр дүнг холбогдох байгууллагад хүргүүлсэн.		
1.7	Арга хэмжээ 4.1. “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/505 дугаар тушаалыг шинэчлэн батлуулах	Батлагдсан тушаал	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/505 дугаар тушаалыг үнэлэх аргачлал, хэрэглэгдэх үүнийг боловсруулж, сонгогдсон аймаг, дүүрэгт үнэлгээг хийсэн.	Тушаалыг эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулна.	“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах зааврыг шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын А/230 дугаар тушаалыг 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр батлуулан, хэрэгжүүлж байна.	2024.01.02 2024.11.29	100%
Зорилт 2: “Хөдөлмөрийн эрүүл ахуй, химийн бодис, хордлогын бодлогын хэрэгжилтийг зохицуулах” зорилтын хүрээнд:							

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
2.1	Эрүүл мэндийн байгууллага бүр эрүүл мэндийн ажилтныг ажлын байрнаас шалтгаалсан халдвар авах нөхцөл, ажлын байрны эрсдэлийн байдалд үнэлгээ хийх нэгдсэн аргачлал боловсруулж, батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Нэгдсэн аргачлалын төсөл боловсруулсан.	Нэгдсэн аргачлалыг эцэслэн боловсруулж, батлуулсан байна.	Эрүүл мэндийн дэмжих сангийн 34,938,500 төгрөгийн санхүүжилтээр АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуультай хамтран эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ хийх нэгдсэн аргачлалыг (6 бүлэг, 45 асуулт бүхий) боловсруулж, АШУҮИС-Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан. Эрүүл мэндийн байгууллагад ажлын байрын орчны эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг хяналтын хуудсын хамт боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулахаар удирдлагуудад танилцуулж, санал авч байна.	2024.01.02 2024.12.31	70%
2.2	Химийн хордлогын бүртгэл, тандалт, мэдээлэх үйл ажиллагааг бэхжүүлэх	Химийн хордлогын бүртгэл, тандалт, мэдээлэх журмын дагуу эмч мэргэжилтнүүдийг сургасан байна.	-	Сургалт зохион байгуулсан байна.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн мэдээлэл солилцох, эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээ авах, эрсдэлийн үеийн харилцаа холбоог сайжруулах, бэхжүүлэх зорилгоор "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах" журмыг танилцуулах цахим сургалтыг 6 хичээлийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн нийт 76 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.	2024.01.02 2024.12.30	100% 
2.3	Угаарын хийн цочмог хордлогын тандалтын нэгжүүдийн бүртгэл, мэдээллийн	Бодит тоо, статистик мэдээ, зөвлөмж, уулзалт, сургалтын тоо	-	Угаарын хийн хордлогод өртсөн, нас барсан иргэдийн тоог гаргах, эрсдэлийг	Угаарын хийн хордлого: ЦТЭ-ийн харъяа ХЯТҮТ, ЭХЭМҮТ, НЭМГ, 21 аймгийн ЭМГ-аас өдөр бүр мэдээ авч, нэгтгэн УОК-ын Нэгдсэн шуурхай штаб-д хүргүүлсэн. 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар Нийслэлийн 7 дүүрэг, 10	2024.01.02 2024.12.30	100% 

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл-тийн хувь
	1	2	3	4	5	6	7
	чанарыг сайжруулах, чадавхжуулах арга хэмжээг зохион байгуулах			бодитоор үнэлэх, чадавхижуулах уулзалт, сургалтыг зохион байгуулсан байна.	аймагт нийт 2489 хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан. 2024 онд химийн хордлогын үйл явдлын 6 тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн. НЭМҮТ-ийн Хор судлал, шуурхай удирдлагын алба, ЭМЯ-ны Хор судлалын мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран Хими, нүүрстөрөгчийн дутуу ислийн цочмог болон архаг хордлогын үеийн тусламж үйлчилгээ, ялган оношлох, олныг хамарсан гамшиг ослын үед эмнэлгийн тусламжийг зохион байгуулах мэдлэг чадвар эзэмшүүлэх зорилгоор "Химийн бодис, нүүрстөрөгчийн дутуу ислийн хордлогын үеийн тусламж үйлчилгээ" сэдвээр цахим сургалтыг 5 хичээлийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн төвүүд, нэгдсэн эмнэлгүүд, БОЭТ-ийн нийт 100 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.		
2.4	Монгол Улсад 2024 онд ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох бодисын жагсаалт, хэрэглэх хэмжээг боловсруулах	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал	2023 онд "Жагсаалт батлах тухай" А/34, А/43, А/50 дугаар хамтарсан тушаал батлагдсан.	Монгол Улсад 2024 онд ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох бодисын жагсаалт, хэрэглэх хэмжээг нэгтгэж,	"Монгол Улсад 2024 онд ашиглаж болох ахуйн хортон шавж мэрэгч устгалын болон халдваргүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох бодисын жагсаалт, хэрэглэх хэмжээ"-г батлах тухай БОАЖЯ, ХХААХҮЯ-тай хамтарсан А/96, А/104, А/81 дүгээр тушаалыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн сангийн 6707 дугаарт 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр бүртгүүлсэн.	2024.01.02 2024.03.30	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
				батлуулсан байна.			
2.5	Ерөнхий сайдын 2022 оны 188 дугаар захирамж: Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын "Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журмын төслийг ЭМЯ-ны удирдлагуудад танилцуулж, санал авч байна.	Журмыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна.	"Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журмыг шинэчлэн батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/74 дүгээр тушаалыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн сангийн 6874 дугаарт 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр бүртгүүлсэн.	2024.01.02 2024.03.30	100%
Зорилт 3. "Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт" зорилтын хүрээнд							
3.1	Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Журмын төсөл боловсруулж байгууллага удаас санал авсан.	Журмыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулна.	Эхийн сүүний нөөцийн банк ажиллуулах журмын төслийг боловсруулах бэлтгэл ажлын хангаж шаардлагатай материал цуглуулах хүрээнд ДЭМБ-ын Зүүн өмнөд Азийн "Эхийн сүүний банкны стандарт"-ыг орчуулсан. Эхийн сүүний нөөцийн банкны журмын төсөл боловсруулах ажлын хүрээнд ЭМЯ, НЭМҮТ, НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөллийг	2024.01.02 2024.12.31	50%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
					оролцуулсан уулзалт зохион байгуулж, ажлын төлөвлөгөө гаргасан. Журмын эхний төслийг боловсруулж, холбогдох газруудаас санал авах албан бичгийг хүргүүлсэн. ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2, Өргөө, Хүрээ амаржих газрууд, Интермед эмнэлгээс ирүүлсэн саналыг тусган эхийн сүүний нөөцийн банк байгуулах журмын төслийг эцэслэн боловсруулж, газар хэлтсийн дарга нараар хянуулан тойруулж байна.		
3.2	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалыг шинэчлэн батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаал	Тушаалыг шинэчлэн батлуулна.	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 27 тоот албан бичгээр ирүүлсэн Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амндэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай" А/74 дүгээр тушаалыг шинэчлэхэд оруулах саналыг үндэслэн тушаалын төслийг боловсруулсан. ХХААХҮЯ, Үндэсний статистикийн хорооны холбогдох албаны хүмүүстэй 2 удаагийн уулзалт зохион байгуулж, хэлэлцүүлсэн. НЭМҮТ-өөс ирүүлсэн саналыг үндэслэн А/74 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралт болох "Жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ"-нд өөрчлөлт оруулах тухай Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулан газар хэлтсийн дарга нараар саналыг аван эрүүл мэндийн сайдаар батлуулахад бэлэн болоод байна.	2024.01.02 2024.12.30	50%
3.3	Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын	Эрүүл мэндийн сайдын тушаал	Хүнсний аюулгүй байдлын	Төлөвлөгөөг батлуулна.	Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр 2024-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилт, нийт 38 үйл	2024.01.02 2024.12.30	50%

120
2

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
	чиглэлээр 2024-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах		чиглэлээр хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан.		ажиллагаатайгаар боловсруулж, ЭМЯ-ны удирдлагуудад тойрох хуудсаар танилцуулсан. БТГ-аас хүнсний аюулгүй байдлын тусгайлсан арга хэмжээний төлөвлөгөө байх шаардлагагүй гэсэн санал өгсөн тул төлөвлөгөөний төслийг дахин боловсруулж, 2024-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болгон Эрүүл мэндийн Дэд сайдаар батлуулахад бэлэн болсон байсан боловч, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөсн тул төлөвлөгөөний төслийг дахин боловсруулж, удирдлагуудад танилцуулан, саналыг авч байна.		
3.4	ЗГҮАХ 2.3.2.6 Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, бусад салбартай хамтран ажиллах	Үйл ажиллагааны төлөвлөгөөний 30 хувийг хэрэгжүүлсэн байна.	2023 оны БШУ-ны сайд, ЭМ-ийн сайд, ХНХ-ын сайдын А/236, А/189, А/80 дугаар хамтарсан тушаал	Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлнэ.	2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөлийн хуралдаан"-д эрүүл мэндийн салбарт 2023 онд хийсэн үйл ажиллагааны тайлан, 2024 оны төлөвлөгөөг танилцуулсан. 2024 оны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Дэд сайдаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон нутгийн орон тооны бус зөвлөл"-ийн гишүүдийг чадавхжуулах тус бүр 100 хүнтэй 2 удаагийн сургалтыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай хамтран зохион байгуулсан. 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Зөвлөлийг ЭМЯ хариуцан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарын хариуцах төлөвлөгөөний	2024.01.02 2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
					хэрэгжилт 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 80%-тай байна. Нярай, бага насны хүүхдийн хооллолтын талаарх зөвлөгөө өгөх сургалтыг 12 аймаг, 2 дүүрэгт 2024 оны 09 дүгээр сарын 16-30-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 540 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. “Олон нийтэд түшиглэсэн нялх, бага насны хүүхдийн хооллолтын дэмжлэгт хяналт, зөвлөгөө-хяналт шинжилгээ” тандагч бэлтгэх сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд зохион байгуулж, 22 сургагч багш бэлтгэсэн. Хоол тэжээлийн цочмог дутлын цогц менежмент сургалтыг зохион байгуулж, нийт 21 аймаг 9 дүүргийн 85 эмч нарыг хамруулан сургаж чадавхижуулав. Олон нийтэд түшиглэсэн нялх бага насны хүүхдийн хооллолтын зөвөлгөө сэдэвт сургалтад 14,500 эцэг эх асран хамгаалагч нарыг хамруулсан. Эх хүүхдийн эрүүл мэндийн ягаан дэвтрийг цахимжуулах ажлыг эрчимжүүлж, хүүхдийн хөгжлийг хянах МОРБАС агуулга нэмж оруулсан.		
3.5	ЗГҮАХ 2.3.10.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан	"MNS 7005: 2023 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол	Стандартыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.	Стандарт хэмжил зүйн газрын 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн "MNS 7005: 2023 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага" стандарт шинээр батлагдсан ба тус стандартыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.	2024.01.02 2024.12.31	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
	стандартын хэрэгжилтийг хангахад хамтран ажиллах		үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага		“Сургуулийн хоол үйлдвэрлэлд тавих хяналтын журам” батлах тухай Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/78, А/238, А/173 дугаар хамтарсан тушаалыг батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн сангийн 6836 дугаарт 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр бүртгүүлсэн. Уг журмын дагуу ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж байна. Дээрх журам батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 28/А/108/А/180 дугаар тушаалыг 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 44/А/308/А/291 дүгээр хамтарсан тушаалаар хүчингүй болгосон.		
3.6	Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг батлуулах	Засгийн газрын тогтоол	-	Техникийн зохицуулалтыг боловсруулж батлуулна.	“Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалт”-ыг шинэчлэн боловсруулж батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/84 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлаар техникийн зохицуулалтын эхний төслийг боловсруулж, 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 6/1432 дугаар албан	2024.01.02 2024.12.30	70%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
					бичгээр холбогдох газруудад хүргүүлэн саналыг авч нэгтгэн, сайжруулалтыг хийсэн. Журмын төслийг хэлэлцүүлэх ээлжит хурлыг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж төслийг засварлан боловсруулсан. Журмын төсөлд 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 6/2913 дугаар албан бичгээр дээрх газруудаас дахин санал авч, нэгтгэн журмын төслийг эцэслэн боловсруулсан. Журмын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 1а/3858 тоот албан бичгээр яамдад хүргүүлж санал авсан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн саналд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг батлуулах асуудлаар холбогдох этгээдийн саналыг авч, бүрдүүлбэрийг хангасны үндсэн дээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан санал авах нь зүйтэй гэж үзсэн тул Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 1а/5150 тоот албан бичгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хандан уг журмыг Засгийн газрын тогтоолоор батлуулах арга хэмжээ авах саналыг хүргүүлсэн.		
3.7	ЭМССТ 1.12 Хүн амын хоол тэжээлийн VI	Судалгааны ажлын тайлан	2017 онд хүн амын хоол тэжээлийн	Хүн амын хоол тэжээлийн VI судалгааны үр	Хоол тэжээлийн VI судалгаанд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн 4 бүс (21 аймаг)-ийн 112 сум, Улаанбаатар хотын 8 дүүргийн 40	2024.01.02 2024.12.30	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
	судалгааны үр дүнг тооцож тайлан гаргах		үндэсний V судалгаа хийгдсэн.	дүнг тооцож тайлан гаргана.	хорооны нийт 17423 хүнийг хамруулсан. Нийт 12 судалгааны багт 60 судлаачид ажилласан. Судалгааны мэдээллийн баазыг "EpiData 3.0" програмд үүсгэж, 7 төрлийн асуулгын шивэлтийг хийж мэдээлэл тайлан боловсруулсан. Судалгааны үр дүнг баталгаажуулахаар судалгаагаар цуглуулсан 4,144 ийлдэсний дээжийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Виллштат хот дахь "ВитМин" лабораторид илгээн төмөр, А аминдэмийн дутлыг илрүүлэх багц шинжилгээ хийлгэсэн. Судалгааны үр дүнг 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр НЭМҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар, 11 дүгээр сарын 27-ны өдөр ЭМЯ-ны дэргэдэх VI судалгааны удирдах зөвлөлийн хурлаар, 11 дүгээр сарын 28-ны өдөр салбар хоорондын 13 байгууллагын 25 эрдэмтэн, судлаач оролцсон уулзалт-хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан. Судалгааны үр дүн, тайлан гарч хэвлэгдсэн.		
3.8	УИХ-ын 36 дугаар тогтоол 5.10 Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах.	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, боловсруулсан мэдээлэл, сурталчилгааны материалын төрөл, тоо	2023 онд "Энэ жилдээ эрүүл жиндээ аян", МҮОНТ-тэй хамтран Эрүүл мэнд теле сэтгүүл нэвтрүүлэг.	Хоол, хүнсний зөв, зохистой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.	"Энэ жилдээ-Эрүүл жиндээ 2" аяныг 2024 оны 02 дугаар сарын 01-нээс 03 дугаар сарын 31-ний өдрүүдэд үндэсний хэмжээнд зохион байгуулж, сошиал постер 38, видео рийлс 2, фото постер 8 боловсруулж олон нийтэд түгээсэн, том сурталчилгааны самбар 5 дүүргийн 10 байршилд, АЗ самбарт 8 хотхонд 300 ширхэг сурталчилгааг байршуулсан. Аяны хүрээнд нийт 11 видео, 30ш зурган контент олон нийтэд цацаж нийт 754925 хүнд хүрч, 12533 удаа хуваалцсан байна. 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан	2024.01.02 2024.12.30 ✓	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
					“Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн нээлтийн арга хэмжээний үеэр иргэд, олон нийт, хүүхдэд зөв зохистой хооллолт, эрүүл хүнсний талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, биеийн жингийн индекс тодорхойлох аргачлалыг зааж, зөвлөгөө өгч ажилласан. - Хүн ам, олон нийтийн эрүүл, зөв хооллолтыг дэмжих, эрүүл хүнсийг сонгон хэрэглэх талаар соён гэгээрүүлэх, боловсролыг дэмжих чиглэлээр 2024 онд давхардсан тоогоор 300 гаруй инфографик (зурагт зөвлөмж)-ийг бүтээж, нийтэд түгээсэн. Үүнд: • Төвийн таргалалтыг үнэлэх, бүсэлхийн тойргийг хэрхэн хэмжих талаар богино хэмжээний видео-1, • хоол хүнсээр дамжих өвчнөөс урьдчилан сэргийлэх видео - 3, • хоол хүнс, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр подкаст - 27, • ТВ ярилцлага - 115, • Сонин болон цахим сайтуудад-15 21 аймгийн Эрүүл мэндийн газарт эрүүл хооллолтын “Гэр” зөвлөмж 1000 ширхэг зурагт хуудас түгээсэн.		
Зорилт 4. “Эрүүл мэндийн боловсрол, салбар хоорондын хамтын ажиллагааны бодлогын зохицуулалт” зорилтын хүрээнд							
4.1	ЗГҮАХ 2.1.1.1, МУХТЖҮЧ 2.2.2 ЭМССТ 1.4 “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлэх.	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Арга хэмжээний хэрэгжилт 50 хувьд хүрсэн.	Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрнэ.	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/780 дугаар тушаалаар “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан. Арга хэмжээний төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 77 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 80.0% хувьтай байна.	2024.01.02 2024.12.30	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.2	ЗГҮАХ 2.1.5.3 Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах	Дэмжлэг үзүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо	Дэмжлэг үзүүлсэн төсөл хөтөлбөр 41, санхүүжилт 1.2 тэрбум төгрөг	Ирүүлсэн төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлнэ	АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах" төслийн хүрээнд хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, контент боловсруулж, мэдээллийн сувгуудаар түгээж байна. Амны хөндийн эрүүл мэнд чиглэлээр 2 богино видео боловсруулж, өргөн нэвтрүүлгийн телевизийн сувгаар түгээсэн. Нийт 54.2 сая төгрөгийн санхүүжилттэй халдварт бус өвчний эрсдэлүүд, амны хөндийн эрүүл мэнд; урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо шинжилгээнд хэрхэн хамрагдах болон түүний ач холбогдол; умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, вакцины ач холбогдол; гэр бүл төлөвлөлт, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт; угаарын хийн хордлого сэдвээр тус бүр 2 инфографик постер, 3 богино видео/рийл боловсруулж, түгээсэн. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, зан үйл, эрүүл мэндийг дэмжих, нийгмийн эрүүл мэндийн тандалт, хяналт, орчны эрүүл мэндийн чиглэлээрх нийт 588 сая төгрөгийн 16 төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлж, Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөс санхүүжилт олгосон.	2024.01.02 2024.12.30	100%
4.3	МУХТЖҮЧ 2.2.2: Зонхилон тохиолдох өвчнөөс	Зохион байгуулсан үйл	2023 оны А/87 тушаал	Төлөвлөгөөний дагуу эрүүл мэндийн	Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх "Харамсахгүйн төлөө хамтдаа" аяныг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 02	2024.01.02 2024.12.30	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
	урьдчилан сэргийлэх, иргэдэд эрүүл идэвхтэй амьдрах, эрүүл зан үйлийг хэвшүүлэх дадлыг бий болгох ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллах	ажиллагааны тоо, тайлан		боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулна.	дугаар сарын 01-ний өдөр хүртэл зохион байгуулж, цуврал контентуудыг ЭМЯ, НЭМҮТ, эрүүл мэндийн байгууллагуудын цахим сувгаар түгээсэн. Эрүүл зохистой хооллолт, дасгал хөдөлгөөнийг дэмжих “Энэ жилдээ-Эрүүл жиндээ 2” аяныг 2024 оны 02 дугаар сарын 01-нээс 03 дугаар сарын 31-ний өдрүүдэд үндэсний хэмжээнд зохион байгуулж, сошиал постер 38, видео рийлс 2, фото постер 8 боловсруулж олон нийтэд түгээсэн, том сурталчилгааны самбар 5 дүүргийн 10 байршилд, АЗ самбарт 8 хотхонд 300 ширхэг сурталчилгааг байршуулсан. Аяны хүрээнд нийт 11 видео, 30ш зурган контент олон нийтэд цацаж нийт 754925 хүнд хүрч, 12533 удаа хуваалцсан байна. Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих “Шүд эрүүл бол шүд эрүүл” аяныг 2024 оны 03 дугаар сарын 20-ноос 05 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Аяныг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж, сошиал постер-26, сошиал видео-17 боловсруулж, ТВ9, малчин ТВ, Боловсрол ТВ, ФМ МЖЛ радиогоор тус тус түгээсэн. Сурталчилгааны самбар 14 хоног байршуулж, 8 контент бүтээгчид, 10 инфлюенсертэй хамтран ажилласан.		
4.4	Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлиг 1.3: Архи, согтууруулах ундаанд ногдуулах	Эрүүл мэндийг дэмжих сангийн төсвөөс санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, тоо	Дэмжлэг үзүүлсэн төсөл, хөтөлбөр 6	Төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/139 дүгээр тушаалаар “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлөгөөний хэрэгжилтийг хангах, нэгдсэн удирдлага, зохион	2024.01.02 2024.12.30	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
	онцгой албан татварын орлогоос архи согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлээр ажиллах				байгуулалтаар хангах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/244 дүгээр тушаалаар “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хамтран хэрэгжүүлж байна. Уг төлөвлөгөөний 3 болон 6 дахь зорилтод архи согтууруулах, ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанууд тусгагдан, хамтран хэрэгжүүлж байна.		
4.5	Засгийн газрын 2023 оны 321 тогтоол, Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг (2024-2027 он) батлуулж, хэрэгжүүлэх	Батлагдсан төлөвлөгөө		Төлөвлөгөөний хэрэгжилтийг 30 хувьд хүргэнэ	“Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/75, А/09, А/34, А/73 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан. Арга хэмжээний төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 54 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 40%-тай байна.	2024.01.02 2024.12.30	100%
4.6	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих салбар дундын нэгдсэн удирдлага, зохион	Эрүүл мэндийн сайдын тушаал	Засгийн газрын 2023 оны 321 тогтоол	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих салбар дундын зөвлөлийг	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих салбар дундын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг ханган ажиллах Зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах удирдамжийг боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Биеийн тамир,	2024.01.02 2024.12.30	100%

2190

5

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	байгуулалтын зөвлөлийг байгуулж, хэрэгжилтийг хангах			байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.	спортын үндэсний хорооноос санал авахаар 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 6/2535 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн. Ирүүлсэн саналыг тусган Зөвлөлийн бүрэлдэхүүнийг ажиллах удирдамжийн хамт Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн "Зөвлөл байгуулах тухай" А/468 дугаар тушаалаар батлуулсан.		
4.7	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох аргачлал, удирдамж боловсруулж, батлуулах	Батлагдсан удирдамж	Засгийн газрын 2023 оны 321 тогтоол	Аргачлал, удирдамж, гарын авлага боловсруулж батлуулна.	Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд зориулсан "Нийгэм, зан үйлийн өөрчлөлтийн харилцаа" гарын авлагын төслийг боловсруулж, хянан, ашиглахад бэлэн болсон. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох "Эрүүл мэндийн боловсрол олгох, зан үйлийг өөрчлөх мэдээлэл харилцааны төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын төслийг боловсруулан, яамны удирдлагуудад танилцуулан саналыг авсан. ХШҮДАГ-аас уг аргачлалыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах шаардлагагүй гэж үзсэн болно.	2024.01.02 2024.12.30	70%
4.8	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын загвар, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Засгийн газрын 2023 оны 321 тогтоол	Шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулна.	Эрүүл мэндийг дэмжигч эмнэлэг, боловсролын байгууллагын загвар, шалгуур үзүүлэлтийг боловсруулахаар хэвлэлийн тойм судалгаа хийж, олон улсын арга, аргачлалыг орчуулж, судлан, төслийг боловсруулсан. Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, гарсан саналыг тусган удирдлагуудаас санал авахад бэлэн болсон.	2024.01.02 2024.12.30	50%
4.9	Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааг зохион байгуулах, төслийн	Төслийн хэрэгжилтийн нэгдсэн тайлан	2023 онд 41 төсөл, хөтөлбөрт 1.2 тэрбум төгрөгийн	Төслийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 78 дугаар тогтоолоор "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах,	2024.01.02 2024.12.30	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
	хэрэгжилтэд хяналт тавин ажиллах		санхүүжүүлт олгогдсон.		хяналт тавих журам" батлагдсан. Журмын дагуу нийгмийн эрүүл мэндийн 2024 оны тэргүүлэх чиглэлийг Эрүүл мэндийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны тэргүүлэх чиглэл батлах тухай" А/396 тоот тушаалаар батлуулсан. Уг тушаалыг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн албан тоотоор НЭМҮТ-д хүргүүлсэн. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/425 тоот тушаалаар "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Нийгмийн эрүүл мэндийн төсөл арга хэмжээг сонгон шалгаруулах" ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, уг ажлын хэсгийн хурлыг 11 дүгээр сарын 05-29-ний өдрүүдэд нийт 3 удаа зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 84 төслийн саналыг хэлэлцэн, нийт 588 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулсан.		
4.10	ЗГҮАХ 2.3.4.6 Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга	Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд холбогдох чиг үүргийн дагуу оролцсон байна	-	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох, сурах бичгийг хүртээмжтэй болгоход чиг үүргийн дагуу оролцоно.	Боловсролын яам, ЖАЙКА Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан "Тэгш хамран сургах боловсрол: сургамж, анхаарах асуудал" семинарт хамтран оролцож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, тусламж үйлчилгээний талаар баримталж буй бодлого, хэрэгжилтийн талаар илтгэл мэдээлэл	2024.01.02 2024.12.30 ✓	100%

69

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
	зүйг боловсронгуй болгох				танилцуулж, тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх арга зүйг боловсронгуй болгох асуудлаарх хэлэлцүүлэгт оролцож, сургалтын хөтөлбөрт тусгуулах санал хүргүүлсэн.		
4.11	ЗГҮАХ 2.3.8.5 Ерөнхий боловсролын сургуулийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлэх	Сургагдсан багшийн тоо	165 багшийг мэргэшүүлсэн.	100 багшийг мэргэшүүлэх сургалтад хамруулна.	Боловсрол, шинжлэх ухааны яам, Азийн Хөгжлийн Банк хамтран хэрэгжүүлж буй "Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл"-ийн хүрээнд төслийн зорилтот аймгууд болох Дархан-Уул, Дундговь, Дорнод аймгийн 100 багш, цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтанд тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээрх сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд зохион байгуулсан. "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл"-ийн хүрээнд тэгш хамруулах боловсрол, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэг, нэмэгдүүлэх, ганцарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 17-27-ны өдрүүдэд зохион байгуулж, бага, дунд ангийн 29 багш, удирдах ажилтныг хамруулсан. Эдгээр төслийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа сургалт, уулзалт хэлэлцүүлэгт оролцож, илтгэл мэдээлэл танилцуулж, санал хүргүүлж, хамтран ажилласан.	2024.01.02 2024.12.31	100%
Зорилт 5. "Амны хөндийн эрүүл мэндийн бодлогын зохицуулалт" зорилтын хүрээнд							
5.1	"Эрүүл шүд" (2024-2027) арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	ЭМС, БШУС-ын хамтарсан тушаал, хэрэгжилтийн хувь, тайлан	Арга хэмжээний төлөвлөгөөн ий төсөл 80%-тай	Төлөвлөгөөг ЭМС, БШУС-ын хамтарсан тушаалаар батлуулсан байна. Тушаалыг	"Эрүүл шүд" (2024-2027) арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/27/А25 дугаар хамтарсан тушаалаар батлан, 6 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр	2024.01.02 2024.12.30	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
				танилцуулах уулзалтыг зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 30 хувьд хүргэнэ	тусгасан. 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 40%-тай байна. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, сэтгүүлчдэд зориулсан шүд, амны хөндийн эрүүл мэнд, эрүүл ахуйн талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулж, 50 гаруй сэтгүүлчдийг хамруулсан. “Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө, “Шүд эрүүл бол бие эрүүл” аяны нээлтийн арга хэмжээг 2024 он 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулж, хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээлэл өгч ажилласан. Мөн энэ үеэр цэцэрлэг, сургуулийн эмч нарт зориулсан чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, 200 эмчийг хамруулсан. Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дунд шүд угаах олимпиадыг зохион байгуулах удирдамж, төсвийг батлуулан, ДЭМБ-д хүсэлт гарган 170.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. 2024 оны 9-10 дугаар “Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн”-ийг дээрх 5 аймагт зохион байгуулж, 9-12 насны хүүхдүүд, багш сурган хүмүүжүүлэгч, гэр бүлийн гишүүдийг оролцуулан нийт 1000 хүүхэд хамрагдсан. Нийслэлийн Ерөнхий боловсролын 50 болон 37-р сургууль дээр шүд угаах өрөөг бий болгож шүд угаах, идэвхжүүлэх кампанит ажлуудыг зохион байгуулсан.		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
					Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/413/А151 дугаар хамтарсан тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг хийх арга хэмжээ"-г хэрэгжүүлэхээр болж нийслэлийн ерөнхий боловсролын 277 сургуулийн 1 дүгээр ангийн 36,000 орчим хүүхдэд үзлэг хийж эхлээд байна.		
5.2	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан амны хөндийн эмгэгээс урьдчилан сэргийлэх үзлэг, шүд фторжуулах тусламж үйлчилгээг үзүүлэх	Урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан ЭМБ-ын тоо, хамрагдсан хүүхдийн тоо	-	Анхан шатны эрүүл мэндийн 10 байгууллага амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулна. 300 хүүхэд хамрагдана.	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, эмгэгээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/413/А151 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн 6 настай суралцагчдад урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулах" ажлын хүрээнд 120 өрхийн эрүүл мэндийн төв болон хувийн хэвшлийн шүдний эмнэлэгүүдтэй хамтран нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн 21,048 орчим хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг, фторт түрхлэг түрхэх ажлууд зохион байгуулсан.	2024.01.02 2024.12.31	100%
5.3	Амны хөндийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа (МСС) явуулах	МСС, арга хэмжээний тоо	Амны хөндийн эрүүл мэнд аяны төлөвлөгөөн ий төсөл боловсруулсан.	10 постер инфографик, 10 видео контент, 5 ярилцлага бэлтгэж олон нийтэд түгээсэн байна.	АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах" төслийн хүрээнд амны хөндийн эрүүл мэнд чиглэлээр 2 богино видео боловсруулж, ЭМЯ, НЭМҮТ-ийн цахим хуудас, МҮОНРТ, Eagle өргөн нэвтрүүлгийн телевизийн суваг болон сайтуудаар түгээсэн.	2024.01.02 2024.12.31	100%

79

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
					Дэлхийн банкны санхүүжилттэй хэрэгжиж буй “Монгол Улсад КОВИД-19 халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл”-ийн хүрээнд амны хөндийн эрүүл мэнд, эрүүл ахуй, шүд угаах аргачлал, шүдний өвчнөөс сэргийлэх сэдвүүдээр инфографик постерийн эх бэлтгэж, хэвлүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад түгээсэн. 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн нээлтийн арга хэмжээний үеэр Нийслэлийн шүд, эрүү нүүрний төвтэй хамтран иргэд, олон нийт, хүүхдэд шүд угаах аргачлал, амны хөндийн эрүүл мэнд, эрүүл ахуйн зөвлөгөө өгсөн. 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн шүд, эрүү нүүрний төвтэй хамтран иргэд, олон нийт, хүүхдүүдэд шүд угаах аргачлал болон амны хөндийн зөвлөгөөг өгөх ажлыг зохион байгуулсан. 2024 оны 9 дүгээр сарын 10-наас 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дунд “Шүд угаалтын аварга шалгаруулах” тэмцээнийг Нийслэлийн Шүд Эрүү Нүүрний Төвтэй хамтран зохион байгуулсан. Тэмцээн 2 үе шаттай зохион байгуулагдаж, шүд угаалтын		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл -тийн хувь
	1	2	3	4	5	6	7
					аварга шалгаруулж, 5 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 9-12 насны 1000 хүүхдүүдийн дунд "Гарын эрүүл ахуй" "Амны хөндийн эрүүл мэнд, шүд угаалт"-ын сургалт зохион байгуулсан. Мөн аймгийн Эрүүл мэндийн газар, Засаг даргын тамгын газартай хамтран тэмцээний аварга шалгаруулах үйл ажиллагаа, цаашид орон нутагт тус тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулах, алслагдсан бүс нутагт амны хөндийн сургалт сурталчилгаа, мэдээ мэдээллийн ажлыг зохион байгуулах сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.		
5.4	Эрүүл ахуйч, тархвар судлаачдын Үндэсний дөрөвдүгээр зөвлөгөөнийг зохион байгуулах	Зөвлөгөөн	Эрүүл ахуйч-тархвар судлаачдын үндэсний гуравдугаар зөвлөгөөн (2016 он)	Эрүүл ахуйч, тархвар судлаачдын Үндэсний дөрөвдүгээр зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.	Эрүүл ахуйч, тархвар судлаачдын үндэсний дөрөвдүгээр зөвлөгөөнийг зохион байгуулах удирдамж, төсвийг боловсруулж, батлуулан ДЭМБ-д хүргүүлж, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Зөвлөгөөнийг 2024 оны 12 дугаар сарын 04-05-ны өдөр "Ирээдүйн төлөөх шийдэл" уриан доор зохион байгуулж, 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг, НЭМҮТ, ЗӨСҮТ, ХӨСҮТ-ийн 150 тархвар судлаач, эрүүл ахуйч нар оролцсон. Зөвлөгөөнөөс гарсан нэгдсэн дүгнэлт зөвлөмжийг нэгтгэн холбогдох газруудад хүргүүлсэн.	2024.01.02 2024.12.31	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

3100

74

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Халдварт өвчний хэлтсийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэх	Хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагаа	-	Хэлтсийн хэвийн үйл ажиллагааг хангасан байна.	Халдварт өвчний хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан. Халдварт өвчний хэлтэс 2024 онд нийт 23 үйл ажиллагаа төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 80%-тай байна.	2024.01.02 2024.09.10	100%
2.	Монголын эмч нарын долоодугаар их хурлыг зохион байгуулах	Зохион байгуулагдсан хурал	Монголын эмч нарын зургаадугаар их хурал	Хурал зохион байгуулагдсан байна.	Монголын эмч нарын долоодугаар их хурлыг зохион байгуулах удирдамж, төсөв, хөтөлбөрийг батлуулан санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Хурлыг зохион байгуулах нарийвчилсан төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажииласан. Хурал Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан. Хуралд төрөлжсөн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн болон бусад салбарын харьяа эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, олон улсын байгууллагын төлөөлөл нийт 900 гаруй төлөөлөгчид оролцсон. Хурлын дараагаар хуралд оролцсон эмч нарт зориулсан хүндэтгэлийн хүлээн авалтыг зохион байгуулсан. Хурлын үйл ажиллагааны тайланг ДЭМБ-д хүргүүлж ажилласан.	2024.09.15 2024.10.18	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх хэмжээ	арга	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
				Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7	
1.1.	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр судалгааны ажил хамтран хийх	Судалгааны ажлын үр дүн Сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэл	-	Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тойм хийсэн байна.	Монгол сурагчдын булчингийн хүч чадал, дасгалын чадавхид Д аминдэмийн бэлдмэлийн нөлөөлөл: санамсаргүй хяналтат туршилт судалгаанд хамтран оролцож, судалгааны дүнг олон улсын хэвлэлд нийтлүүлсэн. (Influence of vitamin D supplementation on muscle strength and exercise capacity in Mongolian schoolchildren: a randomised controlled trial - PubMed (nih.gov))	2024.01.02 2024.12.31	100%	
1.2.	Эрүүл мэнд, анагаах ухаан, удирдлага, менежментийн чиглэлээр богино хугацааны сургалтад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх	Гэрчилгээ, сертификат	2023 онд “Нийгэм, зан үйлийн өөрчлөлт: Мэдээлэл харилцааны стратегийн төлөвлөлт зан үйлд нөлөөлөх харилцаа” (КОМБИ) сургалтад хамрагдсан.	Эрүүл мэнд, анагаах ухаан, удирдлага, менежментийн чиглэлээр богино хугацааны сургалтад хамрагдсан байна.	2024 оны 04 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Филиппин Улсын Манила хотноо зохион байгуулагдсан “Ноцтой байдлын үеийн эрсдэлийн харилцаа холбоог дэмжихэд нийгмийн болон зан үйлийн талаархи ойлголтыг ашиглах нь” сургалтад хамрагдсан. 2024 оны 04 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Зүүн Өмнөд Азийн орнуудын холбоо болох АСЕАН-ы бүсийн “Химийн, биологийн, радиологийн болон цөмийн терроризмтэй тэмцэх эрх зүйн орчныг бэхжүүлэх” сургалт, ширээний дасгал сургуулилтад оролцож, сертификат авсан. 2024 оны 10 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд “Төрийн албаны удирдах албан тушаалтны ур чадварыг хөгжүүлэх нь” цахим, танхим хосолсон нийт 40 цагийн богино хугацааны сургалтад хамрагдаж, №24/1657 үнэмлэх авсан.	2024.01.02 2024.12.31	100%	

ТАЙЛАН ГАРГАСАН:

УСХЗХ-ийн дарга

(Албан тушаал)

Б.Туяа / *Б. Туяа* /

(Нэр, гарын үсэг)

2024.12.10

(Огноо)

39/ 3410

87%

Ж